



## Монгол Улс

# “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” II шат “Төслийн мэдээ” сонин

### Сэдэв:

- СТАРТ-2 төсөл сүүлийн хагастаа орлоо.
- Идэвх, зүтгэл гарган ажиллаж буй салбар комиссууд
- Сургуулийн өмнөх боловсролын ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах
- Дэмжлэг хэрэгтэй хүүхдийн бодит байдлын судалгаа
- Булан “Түгээн дэлгэрүүлэх зорилтот сургуулийн сайн жишээг танилцуулж байна”



 “Төслийн мэдээ” сонины дугаар 3-ыг уншсан танд баярлалаа. Энэхүү дугаартаа бид салбар комиссын гишүүд болон цэцэрлэг, сургуулийн багш нарын өдөр тутмын үйл ажиллагаанд санаа өгөхүйц мэдээллийг голлон нийтэллээ.

### СТАРТ-2 төсөл сүүлийн хагастаа орлоо

2022.08 сараас СТАРТ-2 төслийн сүүлийн хагас эхэллээ.

Төслийн эхний хагаст, Улаанбаатар хотод голчлон тэгш хамран сургах боловсролыг түгээн дэлгэрүүлэхээр ажилласан бол сүүлийн хагаст улсын хэмжээнд үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр зорьж байна.

Бид Монгол Улсын бүс бүрт голлох үүрэг гүйцэтгэх бүсийн төв 5 аймгийг сонгон авсан. Түүнчлэн орон нутгийн цэцэрлэг, сургуулиудад загвар болгох үүднээс бүсийн төв аймгуудад тус бүр 2 цэцэрлэг, сургуулийг сонгон, тэгш хамран сургах боловсролыг хөгжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Нийслэлийн багш, мэргэжилтнүүдтэй хамтран бүсийн төв аймгуудад мониторинг хийн багш нарт зориулсан сургалтуудыг зохион байгуулж байгаа тул эдгээр үйл ажиллагааны явц, сайн жишээ туршлагыг “Төслийн мэдээ” сонин болон фэйсбүүк хуудсаараа дамжуулан түгээсээр байх болно.



(Дээд талд) Бүсийн төв 5 аймаг  
(Доод талд) Мониторинг хийж буй байдал



### Идэвх, санаачлагатай ажиллаж буй салбар комисс

ХНХЯ болон СТАРТ төсөл нь бүх салбар комиссын ээлжит хурал, боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрийн хэрэгжилтэд үзүүлж буй нэмэлт дэмжлэг болон салбар комиссын үйл ажиллагаанд тухайн аймаг, дүүргийн ЗДТГ-аас үзүүлж буй дэмжлэг тусламж, тэгш хамран сургах боловсролын тогтолцоо бүрдүүлж чадсан эсэхтэй холбоотой асуулга судалгаа авсан бөгөөд 2022.11 сар хүртэл нийт 14 аймаг, дүүргийн салбар комисс судалгаанд хариулт өгсөн. Энэ удаагийн төслийн мэдээгээр бусад салбар комиссуудад мэдээлэл болохуйц сонирхолтой хариултуудыг толилуулж байна.

■ “Салбар комиссын гаргасан боловсролд хамруулах тухай шийдвэр нь боловсролд хамрагдахад бодитоор нөлөөлсөн эсэхэд хяналт тавьдаг уу?” гэсэн асуултад 4 аймаг, дүүргийн салбар комисс “Гэрт нь очиж уулздаг, эсвэл утсаар лавладаг”, 9 аймаг, дүүргийн салбар комисс “Цэцэрлэг, сургуульд очиж уулздаг, эсвэл утсаар лавладаг” гэсэн хариулт өгсөн. Мөн “Асаргаа олгох хугацааг богино тогтоож, дараагийн ээлжит хуралд ирэх лавлаж тодруулдаг” гэж 9 аймаг, дүүргийн салбар комисс хариулсан байна.

■ “Аймаг, дүүргийн засаг даргын цэцэрлэг, сургуулиудтай байгуулдаг гэрээнд тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх агуулга багтсан уу?” гэсэн асуултад 13 аймаг, дүүргийн салбар комисс “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэг, сургуульд хүлээн авахаас татгалзаж болохгүй гэсэн заалт багтсан” гэж хариулжээ.

Дорнод аймаг 2016 оноос “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд салбар комиссынхоо үйл ажиллагааг хөтөлбөртөө тусган жил бүр 1 сая төгрөгийн төсөв, ээлжит хурлын өрөөгөөр хангажээ. Аймгийн засаг даргын цэцэрлэг, сургуулиудтай байгуулсан гэрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэг, сургуульд хүлээн авахаас татгалзаж болохгүй” гэсэн заалтыг тусган, салбар комиссын гаргасан боловсролд хамруулах шийдвэр бодитой хэрэгжиж буй эсэхийг утсаар тодруулах зэрэг нэмэлт дэмжлэг үзүүлдэг байна.

2022.11 сард Баян-Өлгий аймаг болон Багахангай дүүргийн салбар комиссууд Улаанбаатар хотод зарим холбогдох байгууллагуудтай танилцах аялалыг зохион байгуулсан. Бусад аймаг, дүүргийнхээ сайн жишээ, туршлагаас санаа авахыг та бүхнээс хүсье.



Багахангай дүүргийн салбар комиссын гишүүд Баянгол дүүргийн салбар комисст айлчлав. (2022.11.30)

## Сургуулийн өмнөх боловсролын ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах

2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр, Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/206 тушаалаар “Сургуулийн өмнөх боловсролын ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө”-ний үлгэрчилсэн загвар болон боловсруулах аргачлалыг батлан гаргасан. Боловсруулах аргачлалд тусгаснаар, СӨБ-ын ГСТ боловсруулах зорилго нь “хүүхэд бүрийн хэрэгцээнд тулгуурласан дэмжлэгийг эцэг эх, асран хамгаалагчтай хамтран, төлөвлөгөөний дагуу, тасралтагүй үзүүлэх” юм. Та бүхэнд СӨБ-д шинээр мөрдөгдөж байгаа ГСТ боловсруулахад анхаарах зүйлсийг танилцуулъя.

### Боловсруулах үед мөрдөх үндсэн алхамууд

1. Зорилтот хүүхдийн бүлгийн багш эсвэл цэцэрлэгийн дэмжлэгийн баг нь хүүхдийн бодит байдлын үнэлгээ, ажиглалтын тэмдэглэл дээрх мэдээллийг үндэслэн, хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд тохирсон зорилт, багшийн дэмжлэг, арга зүйг боловсруулах.
2. Үүнийг ГСТ-нд өгүүлбэр болгон буулгаж, хэрэгжүүлэх, тэмдэглэл хөтлөх.
3. Цэцэрлэгийн дэмжлэгийн багт хуваалцан, эргэцүүлэн дүгнэж, дараагийн зорилт, арга зүйг боловсруулах → 1~3 алхамуудыг давтан хэрэгжүүлэх.

## ГСТ боловсруулахад анхаарах зүйлс

Хөгжлийн бэрхшээлтэй нь тогтоогдсон эсэхээс үл хамааран хөгжлийн бэрхшээлтэй байж магадгүй хүүхэд, үйл ажиллагаанд оролцох, суралцахад дэмжлэг шаардлагатай хүүхдэд зориулж боловсруулахыг зөвлөж байна.

Зорилтот хүүхдийн хэрэгцээнд тохируулан чиглэлээ өөрчилж болно. Зөвхөн “нийгэмшихүй”-д анхааран, зүйлээ нэмэх, шаардлагагүй гэж үзсэн зүйлээ хасаж болно.

Зорилтоо хэт өндөр тавихгүй байхдаа анхаараарай! “Алхам алхмаар” гэсэн бодолтойгоор, гарцаагүй биелэгдэх зорилтыг бичээрэй. Цэцэрлэгийн дэмжлэгийн баг болон эцэг эх, асран хамгаалагчийн саналыг мөн тусгаарай.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө

Хүүхдийн овог нэр		Төрсөн огноо		Боловсруулсан огноо	
		Он	Сар	Өдөр	(О нас О сар)
Бүлэг		Бүлгийн багш			
Хүүхэд болон эцэг эх, асран хамгаалагчийн хүсэл		Бүлгийн багшийн хүсэл			
Зорилго					
Хөгжлийн чиглэл	Хугацаа	Хүүхдийн бодит байдал	Дэвшүүлсэн зорилт	Багшийн дэмжлэг, арга зүй	Хүүхдийн хөгжилд гарсан өөрчлөлт, тэмдэглэл
Нийгэмшихүй	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Бие бялдар, хөдөлгөөн	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Хэл арга	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Боловсрол	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Дүрслэх урлаг	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Дүгнэлт	(Огноо : )				

Хүүхэд бүрийн цэцэрлэгт элсэх өдөр өөр байдаг. Зорилтот хүүхэд элсэн орж ирвэл аль болох хурдан боловсруулж эхлээрэй.

1. Багшийн дэмжлэг, арга зүй өөрчлөгдөж байдаг. Бусад багш нар, бусад байгууллагын мэргэжилтнүүдийн саналыг сонсож, баяжуулаарай.
2. Бүлгийн төлөвлөгөөтэй уялдуулсан дэмжлэгийг бодож олоорой.

“Зорилт биелсэн/ биелээгүй”-гээс гадна хүүхдийн өсөлт хөгжил, үзүүлсэн дэмжлэг, дэвшүүлсэн зорилтуудаа эргэн харж, дараагийн зорилт, дэмжлэгээ дэвшүүлээрэй.

## Хүүхдийн бодит байдлыг үнэлэхдээ анхаарах зүйлс

Эцэг эх, асран хамгаалагчаас өсөлтийн байдал болон амьдралын дадал эвшлийн талаар тодруулдаг цэцэрлэгт элсэхийн өмнөх бодит байдлын үнэлгээ, цэцэрлэгт орсны дараа хүүхдийн “одоо”-г танин мэдэх бодит байдлын үнэлгээ гэсэн 2 арга байдаг.

●Цэцэрлэгт хамрагдахын өмнө: Эцэг эх, асран хамгаалагчтай ярилцлага хийхээс гадна хүүхдийн хамт “туршилтаар цэцэрлэгт хамрагдах” ажлыг зохион байгуулснаар эрхлэгч, арга зүйч, бүлгийн багш энэ үед хүүхдийн үйл хөдлөлийг ажиглах боломжтой болох юм. Мөн, эцэг эх болон хүүхэд ч цэцэрлэгтэй танилцаж, ойлголттой болсноор санаа зовох нь багасна.

●Цэцэрлэгт хамрагдсны дараа: Багш өөртөө ойлгомжтойгоор зорилтот хүүхдийн талаарх ажигласан зүйлээ тэмдэглээрэй. “Өнөөдрийн чиглэл, зорилт”, “хүүхдийн байдал”, “дараагийн алхам”-ыг өдөр болгон тэмдэглэснээр зорилтот хүүхдэд ямар дэмжлэг шаардлагатай байгаа, ямар арга зүй тохирч байгааг аажмаар ойлгодог болж, ГСТ-г боловсруулах бэлтгэл ажил болох болно.



Бүх цэцэрлэгийн хүүхэд хамтаа дуулав.

## Дэмжлэг хэрэгтэй хүүхдийн бодит байдлын судалгаа

Таны ангид оношлогдоогүй, оюун ухааны хувьд хоцрогдолгүй боловч унших, бичихдээ эсвэл тоо бодохдоо тааруу хүүхэд байдаг уу? Магадгүй тэр хүүхдэд бичиг, үсгийн харагдах байдал өөр байх, сонссоноо тогтоож чадахгүй байх гэх мэт асуудал үүсдэг тул сурлагын хоцрогдолд орсон байж болох юм.

### Хичээл хийхэд шаардлагатай чадварууд

Хичээлийн явцад хүүхдүүд янз бүрийн чадваруудыг ашигладаг. Үүнийг танин мэдэхүй гэнэ. Жишээлбэл

- ◆ Багшийн яриаг анхааралтай сонсох ← Анхаарал
- ◆ Багшийн хэлсэнийг богино хугацаанд тогтоогоод дэвтэртээ тэмдэглэх ← Сонсголын богино хугацааны ой тогтоолт
- ◆ Үсэг тэмдэгтүүдийг харж нэг нэгээр ялган таних ← Харааны орон зайн баримжаа
- ◆ Самбарт бичсэн үг, үсгийг харж тогтоогоод хуулж бичих ← Харааны богино хугацааны ой тогтоолт



Эдгээр чадваруудын аль нэг нь сул хөгжсөн хүүхэд олон удаа давтсан ч унших бичих, тоо бодох нь сайжрахгүй хэвээр байдаг. Эргэн тойрны хүмүүс “Оролдвол чадна”, “Сайн хичээхгүй байна” “Хичээлээ давтахгүй байна” гэж боддог, хүүхэд ч өөртөө итгэлгүй болдог. Гэвч багш хүүхдийн сул чадварыг тогтоож, арга зүйгээ өөрчилж үзэх зэргээр ажиллавал ахиц гарах боломжтой. Өнөөдөр бүгдээрээ “Унших” чадвар сул хүүхдийн онцлогтой танилцъя.

### Алгасч уншдаг, тааж уншдаг хүүхдийн танин мэдэхүйн онцлог

Чанга тод унших үедээ үг, мөр алгасдаг, тааж уншдаг, урт эгшиг, я-гийн төрлийн үсэгнүүдийг буруу дууддаг хүүхдүүдэд дараах танин мэдэхүйн чадвар сул байх магадлалтай.

- ◆ Үсэг нэг бүрийг анхаарахгүй байх (Анхаарал): Үг бүтээж буй үсэг нэг бүрийг анхаарч уншихгүй бол зөв дууддаг чадахгүй.
- ◆ Дүрсийг ялган таних (Хараагаар хүртэх танин мэдэхүй): Ижил төстэй үсэгнүүдийг ялган таних, харснаа тогтоох чадвар муу тохиолдолд уншлага, дуудлага буруу болно. Ялангуяа бичмэлээр бичсэн үгнүүдийг үеэр салгаж уншихад хүндрэлтэй тул хараагаар хүртэх танин мэдэхүй сул тохиолдолд уншихдаа муу байх нь элбэг.

ч ↔ ʒ ш ↔ ш Төстэй дуудлагатай үсгийг ялган сонсохгүй, андуурч бичих, сонсох.

- ◆ Авиаг ялган таних (Сонсголоор хүртэх танин мэдэхүй): Ижил төстэй дууддаг авиаг ялган танихдаа муу хүүхэд тэдгээр үг, үсгийг уншиж бичихдээ алддаг.

g ↔ m z ↔ ж Үсэг хоорондын залгааг ялгахгүй, буруу дууддаг унших.


- ◆ Уншихдаа нүд гүйцэхгүй байх (Харааны хөдөлгөөн удаан): Уншиж байгаа зүйлд нүд гүйцэхгүй, өөр үгэн дээр харж байгаа тохиолдол шалтгаан нь байж болзошгүй. Эсвэл үсэг эсрэгээрээ харагдах, үгнүүд нэг мөрөн дээр харагдахгүй байх гэх мэт шалтгаан байх тохиолдол байдаг гэнэ.

„днем лүүүе хелүүеү дедхүүү йтгьтлрдгвш пофзволод теелгедех йтгзүт“  
“лөөэт хвлүүржйбэ теегллнлүү нлплбгтмх нйнмтйнн лорзволод

Э гар уралдааны “Миний ертөнц” сэдвээр сан  
нэхүү зургийн зохион байгуул  
бөгөөд ХУД өөрсдийн төсө лдөг ертөнцийг чөлөөтэ а дүрслэн  
илэ хийл юм.

### Уншихдаа муу хүүхэдтэй ажиллах арга зүй

- ◆ Зөвхөн алдаж уншдаг үгнүүдийг тодорхойлж, зөв, хурдан унших дасгал хийх
- ◆ Дуудахад хэцүү хэсгийг, чухал үгнүүдийг өнгө ялган тодруулах, доогуур нь зурах зэргээр анхааруулах
- ◆ Самбараас буруу хуулдаг хүүхдэд цаасан дээр урьдчилан бэлдсэн самбарын бичиглэлийг өгөх
- ◆ Шугам барьж өөр мөр лүү шилжүүлэхгүй байх
- ◆ Цагаан толгойн картыг барьж хамтдаа дуудаж унших
- ◆ Урт эгшиг, я-гийн төрлийн үсэг зэрэг уншихад хэцүү хэсэг дээр тэмдэг тавих



## Булан “Түгээн дэлгэрүүлэх зорилтот сургуулийн сайн жишээг танилцуулж байна”

2021 оны 5-р сараас 2022 оны 6-р сар хүртэл Улаанбаатар хотын 9 дүүргээс 25 сургуулийг төслийн түгээн дэлгэрүүлэх зорилтот сургуулиар сонгож, тэгш хамран сургах боловсролыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан. Зорилтот сургуулиудын сайн туршлагаас өнөөдөр та бүхэнд “Туслах хэрэгсэл”, “Унших бичихэд зориулсан дэмжлэг”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө(ГСТ) боловсруулснаар багшид гарсан өөрчлөлт”-ийн тухай танилцуулах болно.


### Туслах хэрэгсэл: Хүүхдийн үйл ажиллагааг дэмжих

НЕБ-ын Оюуны Ундраа цогцолбор сургууль бага ангийн хүүхдүүд угаалтуур ашиглахад хялбар болгох, ангийн босгыг налуу болгох зэрэг түгээмэл загвар бүхий орчин бүрдүүлэлтийг хийжээ. Зөврийн пандусыг угаалтуурын урд байршуулснаар хүүхэд өөрийнхөө гарыг харж, зөв угаах боломжтой болсноос гадна ханцуйгаа норгох нь багассан. Мөн зөврийн пандусыг ашиглан ангийн босгыг налуу болгосноор тэргэнцэртэй хүүхэд чөлөөтэй орж гарахаас гадна хүүхдүүд босгонд бүдрэх нь багассан гэх мэт олон сайн тал ажиглагдсан. (Баянгол дүүргийн Оюуны ундраа ЦС)



### Унших бичихэд зориулсан дэмжлэг: Өөртэй итгэлтэй уншиж сурах, унших чадварыг сайжруулах


Төслөөс зохион байгуулсан сургалтын үеэр Монгол хэлний хичээл дээр зураг ашиглах нь хүүхдийн ойлголтын түвшинг дээшлүүлдэг тухай танилцуулсан. Сурсан мэдлэгээ ашиглан Сүхбаатар дүүргийн 6-р сургуулийн багш “Зурагт эх” хэрэглэгдэхүүн боловсруулсан. Уншихдаа асуудалтай хүүхдэд энэ хэрэглэгдэхүүнийг ашигласнаар өөртөө итгэлтэй, чанга дуугаар уншиж сурсан. Коронавирусын улмаас цэцэрлэгтэй яваагүй, суурь чадвар эзэмшээгүй хүүхдүүд 1-р ангид олон байна. Зөвхөн бичвэр биш олон зурагтай, хэн бүхэнд ойлгомжтой энэ хэрэглэгдэхүүнийг ашигласнаар хүүхдүүдийн унших чадвар дээшилсэн. Зурагт хэрэглэгдэхүүнийг ашиглан хичээллэсэн 1-р ангийн сурагчид болон энэ хэрэглэгдэхүүнийг ашиглаагүй 2-р ангийн сурагчдын дундаж унших чадварыг харьцуулахад 1-р ангийн сурагчид илүү өндөр оноо авсан.



### ГСТ боловсруулснаар багшид гарсан өөрчлөлт: Багш, хүүхэд, эцэг эх асран хамгаалагчийн өөрчлөлт гарсан өөрчлөлт

Баянзүрх дүүргийн 79-р сургуульд ГСТ боловсруулснаар олон багшийн хандлага өөрчлөгдсөн тухай хэлж байсан. Тэгвэл ямар өөрчлөлт гарсныг харцгаая.

- ◇ ГСТ боловсруулдаггүй байхдаа зорилтот хүүхдийг мартаж тохиолдол байсан ч, одоо тухайн хүүхэдтэй хэрхэн ажиллахаа бодож төлөвлөдөг болсон. Жишээ нь, анги нийт дунд суралцахад хүндрэлтэй байсан хүүхэдтэй ганцаарчилж ажилласнаар хүүхдийн ойлголт сайжирч, хичээлдээ идэвхтэй болж, багштайгаа хамт хичээлээ хийх дуртай болсон.
- ◇ Зөвхөн ГСТ боловсруулдаг хүүхэд биш бусад дэмжлэг шаардлагатай хүүхдийг ч анхаардаг болсон.
- ◇ Хүүхдүүдээ ойлгохыг хичээдэг болсон. Асуудалтай зан үйлийн шалтгаан, чаддаг зүйл, чаддаггүй зүйлийг ажигладаг болсон. Ингэснээр хүүхдүүд хичээлдээ дуртай, идэвхтэй болж, багш хүүхдийн харилцаа сайжирсан.
- ◇ Эцэг эхэд нь ГСТ-өөр хичээллэх тухай хэлэхэд эхэндээ эсэргүүцэж байсан. Гэвч ГСТ-ний дагуу хичээлийн агуулгыг хялбарчилснаар хүүхдийн ойлголт дээшилж, өөртөө итгэх итгэл нь нэмэгдсэн. Хүүхэд нь хичээлдээ дуртай болж, ахиц гарахыг харсан эцэг эхийн ойлголт, хандлага сайжирч, багш, хүүхэд, эцэг эх нэгдсэн ойлголттой болсон.



Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Авзага трейд байр, 505 тоот



<https://www.facebook.com/JICA.START.2>



<https://www.jica.go.jp/project/mongolia/029/index.html>



[jicastart2@gmail.com](mailto:jicastart2@gmail.com)



+976-80486690  
+976-95937356

